## "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН АВИЛГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2021 оны 12 дугаар сарын 8-ны өдөр

Авилгатай тэмцэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомж, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэв.

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хийгдэх ажил | Хугацаа | Хариуцах этгээд | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах албан тушаалтны ХАСУМ-ыг хянасан байдлыг үндэслэн томилгоо хийх. | Шинээр томилогдохоор нэр дэвшиж буй хүний ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлэн хянуулна. | Тухай бүр | Захиргаа, хүний нөөцийн хэлтэс | Тус компанийн эрх бүхий албан тушаалтнаар томилогдхоор нэр дэвшсэн хүмүүсийн ХАСУМ-ыг тухай бүр АТГ-т хүргүүлэн хянуулж санал авч ажиллаж байна. 2020 онд эрх бүхий албан тушаалтнаар томилогдохоор нэр дэвшсэн 5, ТУЗ-ийн 9 нийт 14 хүний ХАСУМ-ыг хүргүүлж санал авсан байна. |
| | | АТГ-аас ХАСУМ-ыг хянаж, дэмжсэн нэр дэвшигчийг эрх бүхий албан тушаалтнаар томилно. | Тухай бүр | Захиргаа хүний нөөцийн хэлтэс | АТГ-аас ХАСУМ-ыг хянаж дэмжсэн 5 эрх бүхий албан тушаалтан болон ТУЗ-ийн 9 гишүүнийг томилсон. |
| 2 | Авлигын эсрэг хуулийн 4.1.3, 6.1.8, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 4.1, 24.1.5-д заасныг хэрэгжүүлэх. | Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ыг хуульд заасан хугацаанд гаргуулан цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах. | I улиралд | Хууль, эрх зүйн хэлтэс | Компанийн эрх бүхий тушаалтанууд болон ТУЗ-ийн гишүүн нийт 17 хүнээс ХАСХОМ-ийг хуульд заасан хугацаанд гаргуулан Авлигатай Тэмцэх Газрын цахим системд бүртгэсэн. Мөн 2020 онд хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон 4 эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг цахим системд бүртгэж баталгаажуулсан. |
| | | Холбогдох тайлан мэдээг гаргаж АТГ, ЭТТ ХК-ын эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх. | I улиралд | Хууль, эрх зүйн хэлтэс | Тус компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийн тайланг нэгтгэн АТГ, ЭТТ ХК-д хуульд заасан хугацаанд албан бичгээр хүргүүлсэн. |
| 3 | Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл гаргах ажлыг хэвшүүлэх. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тендерийн Үнэлгээний хороонд томилогдсон ажилтнууд шийдвэр гаргахын өмнө ашиг сонирхлын | Тухай бүр | Худалдан авалт, хангамжийн хэлтэс | 7 Нээлттэй тендерт оролцсон нийт 46 гишүүнээс, 11 харьцуулалтын аргаар худалдан авалт хийх нийт 55 гишүүнээс ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдүүлэг гаргуулан АТГ-ын meduuleg.iaac.mn сайтад шивсэн. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж хэвших | | | |
| | | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтнууд шийдвэр гаргахын өмнө ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж хэвших. | Тухай бүр | Эрх бүхий албан тушаалтнууд | Тендерийн үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтийн дагуу бараа, ажил үйлчилгээ худалдан авах 17 гэрээ байгуулахад эрх бүхий албан тушаалтнаар ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдлийг гаргуулан АТГ-ын meduuleg.iaac.mn сайтад шивсэн. |
| 4 | Компанийн ёс зүйн зарчмыг тогтоож, дагаж мөрдөх | Ёс зүйн дүрмийг шинээр томилогдсон ажилтан бүрт тухай бүр нь танилцуулж байх | Тухай бүр | Захиргаа хүний нөөцийн хэлтэс | Ёс зүйн дүрмийг компанид шинээр орсон ажилтнуудад зориулсан чиглүүлэх сургалтын агуулгад оруулан танилцуулах ажил хийгдэж байна. |
| | | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтэнд хяналт тавих, ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэх | Тухай бүр | Ёс зүйн хороо | Тайлангийн хугацаанд ёс зүйн зөрчилтэй холбоотой 3 өргөдөл, баримт ирснээс зөрчил гаргасан 1 ажилтанд Ёс зүйн дүрэмд заасны дагуу “уучлал гуйхыг үүрэг болгож” шийдвэрлэсэн. Мөн зөрчил гаргасан 1 ажилтан өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас чөлөөлөгдөж, 3 ажилтанд холбогдох асуудлыг хянан шалгаж байна. |
| 5 | Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл гомдол, мэдээллийг хүлээн авах, шалгах, хариуцлага хүлээлгэх | | | | |
| | | Авилга, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авч хянан шалгах, шаардлагатай бол АТГ-т шилжүүлж шалгуулах. | Тухай бүр | Дотоод аудитын алба | Тайлангийн хугацаанд авилга, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл ирээгүй. |
| | | Авилга гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзсэн компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, шийдвэр, үйл ажиллагааг өөрчлөх буюу хүчингүй болгох. | Тухай бүр | Дотоод аудитын алба | Компанийн дотоод үйл ажиллагаанд мөрдөх дүрэм, журам, заавар, шийдвэр, үйл ажиллагаанд авилга гарах нөхцөл боломжийг бүрдүүлсэн гэж үзэхүйц асуудал илрээгүй. |
| 6 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах | Тендерийн урилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон цахим хуудсаар мэдээллэж байх | Тухай бүр | Худалдан авалт, хангамжийн хэлтэс | 17 үнэлгээний хороо байгуулагдсанаас<br>6 нь нээлттэй тендер зарлаж сонинд,болон цахим хуудсанд, 11 нь харьцуулалтын аргаар худалдан авалт хийх зарыг цахим хуудсанд байршуулж нийтэд мэдээлж ажилласан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | ажиллагааны ил тод байдлыг хангах | Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд мэргэжлийн холбоод, ТББ-ын төлөөллийг оролцуулах | Тухай бүр | Худалдан авалт, хангамжийн хэлтэс | Үнэлгээний хороонд ТББ-ын 2 хүнийг байнга оролцуулан ажилласан. |
| | | Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг цахим хуудсанд мэдээлэх | Тухай бүр | Худалдан авалт, хангамжийн хэлтэс | Нийт 17 бараа ажил үйлчилгээний худалдан авалтын үр дүнг цахим хаягт байршуулсан. |
| 7 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах | Тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд мэдээлэх | Хуульд заасан хугацаанд | Санхүү, эдийн засгийн газар | Нууцад хамаарагдахаас бусад төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төсөл, жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд мэдээллэж ажилласан |
| | | Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг мэдээлэх /Шилэн дансанд байршуулах/. | Хуульд заасан хугацаанд | Санхүү, эдийн засгийн газар | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд санхүүжилтын мэдээ, тайланг сар тутамд цахим системд хуулийн хугацаанд нь нийт 145 мэдээг байршуулж баталгаажуулсан. |
| 8 | Компанийн хүний нөөцийн ил тод байдлыг хангах | Компанийн сул орон тооны зарыг цахим хуудсанд байршуулах | Тухай бүр | Захиргаа хүний нөөцийн хэлтэс | Компанийн сул 24 орон тооны зарыг цахим хуудсанд байршуулсан. |
| | | Компанийн ажилтны сонгон шалгаруулалт явуулах талаар нээлттэй зарлаж байх | Тухай бүр | Захиргаа хүний нөөцийн хэлтэс | 24 орон тооны зар тавьж нийт 82 ажил горилогчдын анкет хүлээн авч сонгон шалгаруулалт хийсэн. |
| 9 | Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах | Авлигатай тэмцэх газраас санал зөвлөмж ирүүлбэл биелэлтийг зохион байгуулах | Тухай бүр | Захиргаа удирдлагын газар | -Ковид-19 халдварын нөхцөл байдлын улмаас АТГ-аас ирүүлсэн зөвлөмжийн дагуу компанийн эрх бүхий албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хугацаанаас нь өмнө гаргуулан авч баталгаажуулсан.<br>-АТГ-аас ирүүлсэн хүсэлтийн дагуу компанийн ажилтан, ХАСХОМ мэдүүлэгч нарын дэлгэрэнгүй судалгааг гаргаж, бүтэц орон тоо, эрх бүхий албан тушаалтнуудыг томилсон шийдвэрийн хуулбарын хамт цахим болон албан бичгээр АТГ-т хүргүүлж хамтран ажилласан. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | Авлигатай тэмцэх газраас зохион байгуулж байгаа сургалт, хурал зөвлөгөөнд холбогдох ажилтныг оролцуулж байх | Тухай бүр | Захиргаа удирдлагын газар | АТГ-ын холбогдох ажилтантай хамтран Авилга, ашиг сонирхлын зөрчлийн талаар цахим сургалт зохион байгуулж тус компантийн эрх бүхий албан тушаалтнуудыг бүрэн хамруулсан. |

Танилцсан:
Захиргаа удирдлагын газрын дарга Ц.Болд

Хянасан:
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга И.Идэш

Боловсруулсан:
Мэргэжилтэн В.Лхагвадорж